

**МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН
2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2025 ОНЫ
ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ГУРАВ ДАХЬ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2024 оны 11 дүгээр
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 31, 11 дүгээр сарын 01-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед олонхын дэмжлэг авсан саналуудыг төсвийн төсөл болон холбогдох хавсралтуудад тусган гурав дахь хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийх үед Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулгыг хийх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгасан болно:

1.Төсвийн төсөлд тусгагдсан зарим төсвийн ерөнхийлөн захирагч нарын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах чиг үүргийн дагуу урсгал болон хөрөнгийн зардлыг хооронд нь шилжүүлэх замаар тэдгээрийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.

2.Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагуудыг үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай барилга байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүжилтийн эх үүсвэрийг төсвийн төсөлд нэмж тусгалаа.

3.Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэн эрсдэлийн санд тусгагдсан санхүүжилтийг шилжүүлсэн.

Монгол Улсын 2025 оны төсвийн жилд нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн **36,830,456.0** сая төгрөг байхаар, үүнээс Тогтворжуулалтын санд 608,889.9 сая төгрөг, Үндэсний баялгийн санд 2,356,827.3 сая төгрөг хуримтлуулахаар төсвийн төсөлд тусгалаа. Ингэснээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 33,864,738.8 сая төгрөг болохоор байна.

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн **35,771,913.2** сая төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,932,825.6 сая төгрөг буюу дотоодны нийт бүтээгдэхүүний 2.0 хувьтай, тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон төсвийн тэнцэл -1,907,174.4 сая төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний -2 хувьтай тэнцэхээр буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэхээр байна.

Түүнчлэн, Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг дотоод, гадаад үнэт цаас гаргах замаар нөхөх боломжтой гэж үзлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд дээрх өөрчлөлтүүдийг тусгахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудад заасан шаардлагыг баримталсан.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдэд өөрчлөлт оруулсан төслийн эцсийн хувилбарыг нэгдсэн хуралдаанд танилцуулж, төслүүдийг батлуулах нь зүйтэй гэж үзлээ.


Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн эцсийн хувилбар болон холбогдох хавсралт, тооцоог Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ДАВААСҮРЭН